



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/157

Номгон

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах¹
орон тооны бус салбар зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга-Аймгийн Засаг даргын Нийгмийн бодлого, байгаль орчны асуудал хариуцсан Орлогч

Орлогч дарга-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Соёл, урлагийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Хүний эрхийн үндэсний комиссын Баянхонгор аймаг дахь төлөөлөгч (Зөвшилцсөнөөр)

Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн төрийн бус байгууллагын Тэргүүн (тохиролцсоноор)

Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн Тэргүүн (тохиролцсоноор)

Аймгийн Тэргэнцэртэй иргэдийн холбооны Тэргүүн (тохиролцсоноор)


2.

Нарийн бичгийн дарга: Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр нийгмийн хамгаалал, халамж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан мэргэжилтэн

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/74 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН